



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

АРХАНГАЙ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Дэмид жанжны 3-300 тоот, 1 дүгээр баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65141
Утас: (976) 7033 3632, 7033-3633
Цахим шуудан: arkhangai@gazar.gov.mn
Цахим хуудас: www.arkhangai.gazar.gov.mn

№ 10/Н.03/13 № 107
танай _____-ны № _____-Т

ӨНДӨР-УЛААН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Ю.БААСАНЖАРГАЛ ТАНАА

Сумын 2024 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Өндөр-улаан сумын Бэлхи, Донгой багийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын зургийн даалгаврыг боловсруулж, баталгаажуулан хүргүүлж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажиллана уу.

Зургийн даалгаврыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт . 8 хуудастай.

ДАРГА  Ч.ОТГОНЖАРГАЛ



6524020388

БАТЛАВ.
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.ЦЭРЭННАДМИД

**АРХАНГАЙ АЙМГИЙН ӨНДӨР-УЛААН СУМЫН ДОНГОЙ БАГ, БЭЛХИ БАГИЙН
ТӨВИЙН УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ ДАГУУХ ХЭСЭГЧИЛСЭН
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ ЗУРГИЙН ДААЛГАВАР**

2024 оны 02-р сарын 19-ны өдөр Дугаар: 04/2024

1.	Боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none">• Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”• Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт;• Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”;• Архангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.3 дахь заалт;• Өндөр-Улаан сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
2.	Байршил, эдийн засаг нийгмийн хөгжлийн байдал	<p>Архангай аймгийн Өндөр-Улаан сум нь 1923 онд байгуулагдсан, хуучнаар Халхын Сайн ноён хан аймгийн Цэцэн Чин вангийн хошуунд харъяалагдаж байжээ.</p> <p>Азарга, Хануй, Донгой, Бэлхи, Баянгол гэсэн 5 багтай. Архангай аймгийн баруун хойд хэсэгт байрладаг Улаанбаатар хотоос 612 км, Аймгийн төвөөс 122 км зайд байрладаг, Эрдэнэмандал, Ихтамир, Чулуут, Тариат, Жаргалант сумдтай хиллэдэг.</p> <p>Далайн төвшнээс дээш 1500-2800 м өргөгдсөн. Физик газар зүйн хувьд Хангай, Хэнтийн уулархаг муж, геоморфологийн хувьд, Хангайн нурууны гол нуруу түүний салбар хэсэг тойрог уулсын мужид хамаарна.</p> <p>Өндөр-Улаан сумын Донгой баг нь 1958 онд Хайрханы өвөлжөөнд хурал хийж “Хануйн хөгжил” нэртэй арван долоон гишүүнтэй байгуулагдаж байжээ Донгой баг нь баруунаасаа зүүн тийш сунаж тогтсон урд талаараа Ихтамир сум Борт багтай, Баруун талаараа Чулуут сум Халуун ус багтай, Хойд хэсгээр Бэлхи багтай Зүүн талаараа Хануй багтай хиллэдэг.</p> <p>Өндөр-Улаан сумын Бэлхи баг нь 1942 онд дараах газруудад нутаглагч ардын аж ахуйтны зургаан багаас бүрдэж байжээ. Үүнд: Зургаадугаар баг- Давхар хүрмээс Бумбат хүртэл, Долоодугаар баг- Чулуут голын урд талаар, Наймдугаар баг Шива ширээтийн Хүрээний буйраас Мухар шавар, Дөрөлж, Сонгинот хүртэл, Есдүгээр баг- Тэгш булангаас Ханхар, Цахир, Их шавар Зуун салаа мод, Намшир, Зүүн цахир, Аравдугаар баг- Цагаан булаг,</p>

		<p>Баруун мухар, Салхит, Хэрэм, Дэлгэр булаг, Арван нэгдүгээр баг-Шар булаг, Эрээн мод, Тэргэн толгой, Бэлхийн рашаант, 1959 онд тус багуудыг нэгтгэн 3-р бригад нэртэйгээр одоогийн Чулуут голын гүүрний баруун урд шаврын голын хойно байх хуучин "Цогт" сүм байсан модон байшингуудыг түшиглэн байгуулагдсан.</p> <p>2023 оны жилийн эцсийн байдлаар Өндөр-улаан суманд 1648 өрхийн 5749 хүн амьдарч байгаагаас Донгой багт 853 хүн, Бэлхи багт 1207 хүн амьдарч байна.</p>
3.	Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ (га)	<p>Өндөр-улаан сумын Донгой багийн төвөөс Хануй голын гүүр хүртэл, Бэлхи багийн Чулуут голын гүүрнээс Халзан бүргэдэй хүртэлх улсын чанартай авто замын дагуух суурьшлийн бүсийн газар нутаг хамаарна.</p> <p>/төлөвлөлт хийх газрын хил хязгаарыг бэлтгэл ажилд үндэслэн захиалагч, орон нутагтай харилцан тохирно/</p>
4.	Боловсруулах ажлын үе шат	<ol style="list-style-type: none"> 1. Бэлтгэл ажил: <ul style="list-style-type: none"> • Байр зүйн зураглалын тодруулалт, • Дэд бүтцийн техникийн нөхцөл авах, • Одоогийн байдлын судалгаа, • Инженер-геологийн судалгаа, дүгнэлт, • Олон нийтийн хэлэлцүүлэг; • Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ; 2. Өндөр-Улаан сумын багийн төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 6 дугаар хэсэгт заасан бүрдэлтэйгээр боловсруулах; 3. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;
		<p>Монгол улсын хуулиуд:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Үндсэн хууль • Хот байгуулалтын тухай хууль; • Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль; • Барилгын тухай хууль; • Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; • Байгаль орчныг хамгаалах тухай хууль; • Соёлын өвийг хамгаалах тухай хууль; • Аялал жуулчлалын тухай хууль; • Ойн тухай хууль • Усны тухай хууль; • Хот суурин газрын усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль; • Эрчим хүчний тухай хууль; • Газрын тухай • Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; • Геодези зураг зүйн тухай хууль; • Гамшгаас хамгаалах тухай хууль; • Галын аюулгүй байдлын тухай хууль; • Харилцаа холбооны тухай хууль; • Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль; • Шуудан холбооны тухай хууль; • Авто замын тухай хууль;

		<p>Баруун мухар, Салхит, Хэрэм, Дэлгэр булаг, Арван нэгдүгээр баг-Шар булаг, Эрээн мод, Тэргэн толгой, Бэлхийн рашаант, 1959 онд тус багуудыг нэгтгэн 3-р бригад нэртэйгээр одоогийн Чулуут голын гүүрний баруун урд шаврын голын хойно байх хуучин "Цогт" сүм байсан модон байшингуудыг түшиглэн байгуулагдсан.</p> <p>2023 оны жилийн эцсийн байдлаар Өндөр-улаан суманд 1648 өрхийн 5749 хүн амьдарч байгаагаас Донгой багт 853 хүн, Бэлхи багт 1207 хүн амьдарч байна.</p>
3.	Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ (га)	<p>Өндөр-улаан сумын Донгой багийн төвөөс Хануй голын гүүр хүртэл, Бэлхи багийн Чулуут голын гүүрнээс Халзан бүргэдэй хүртэлх улсын чанартай авто замын дагуух суурьшлийн бүсийн газар нутаг хамаарна.</p> <p>/төлөвлөлт хийх газрын хил хязгаарыг бэлтгэл ажилд үндэслэн захиалагч, орон нутагтай харилцан тохирно/</p>
4.	Боловсруулах ажлын үе шат	<ol style="list-style-type: none"> 1. Бэлтгэл ажил: <ul style="list-style-type: none"> • Байр зүйн зураглалын тодруулалт, • Дэд бүтцийн техникийн нөхцөл авах, • Одоогийн байдлын судалгаа, • Инженер-геологийн судалгаа, дүгнэлт, • Олон нийтийн хэлэлцүүлэг; • Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ; 2. Өндөр-Улаан сумын багийн төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг 6 дугаар хэсэгт заасан бүрдэлтэйгээр боловсруулах; 3. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;
		<p>Монгол улсын хуулиуд:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Үндсэн хууль • Хот байгуулалтын тухай хууль; • Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль; • Барилгын тухай хууль; • Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; • Байгаль орчныг хамгаалах тухай хууль; • Соёлын өвийг хамгаалах тухай хууль; • Аялал жуулчлалын тухай хууль; • Ойн тухай хууль • Усны тухай хууль; • Хот суурин газрын усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль; • Эрчим хүчний тухай хууль; • Газрын тухай • Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; • Геодези зураг зүйн тухай хууль; • Гамшгаас хамгаалах тухай хууль; • Галын аюулгүй байдлын тухай хууль; • Харилцаа холбооны тухай хууль; • Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай хууль; • Шуудан холбооны тухай хууль; • Авто замын тухай хууль;

5.	Боловсруулахад ашиглах материал	<ul style="list-style-type: none"> • Эрүүл ахуйн тухай хууль; • Хог хаягдлын тухай хууль; • Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; • Хөрөнгө оруулалтын тухай хууль; • Орон сууцны тухай хууль; • Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль; • Бусад хуулиуд. <p>Хөтөлбөрүүд:</p> <ul style="list-style-type: none"> • “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” • Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого; • Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр; • Архангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр; • Тухайн бүс нутаг, аймаг суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд; • Салбаруудын хэмжээнд хэрэгжиж байгаа бусад төсөл хөтөлбөрүүд аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний баримт бичигтэй уялдуулах; • Аймаг, сумыг хөгжүүлэхээр батлагдсан бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах. <p>Норм, нормативууд:</p> <ul style="list-style-type: none"> • Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30.01.04/; • Хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах аргачилсан заавар /УББ 11-202-00/; • Хот суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар / УББ 30-201-09/; • Хот, тосгоны улаан шугам төсөллөх ба тогтоох заавар /УББ 30-202-11/ • Барилгын инженер-геологийн ажил /БНБД 11-03-01/; • Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл БНБД 11-07-04; • ЗТБХБ-ын Сайдын 2011 оны 226 дугаар тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм”; • ЗТБХБ-ын Сайдын 2012 оны 183 дугаар тушаалаар батлагдсан “Хот, тосгоны ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам”; • MNS 6736:2018 “Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг”; • MNS 5873:2008 “Барилгын зураг. Ерөнхий төлөвлөгөөний ажлын зургийн таних тэмдэг”; • MNS ISO 11091:2007 “Барилгын зураг. Ландшафтын зураг боловсруулах”; • MNS 6055:2009 “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар”
----	---------------------------------	--

		<ul style="list-style-type: none"> • MNS 5682:2006 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зайн төлөвлөлт” • Авто зогсоол БНБД 21-05-10; • Хот суурины гудамж, зам төлөвлөлт БНБД 31-01-04; • ГХГЗЗГ-ын даргын 2014 оны А/112 дугаар тушаал, /Солбицлын эринг батлах тухай/ • ГХГЗЗГ-ын даргын 2014 оны А/261 дугаар тушаал, /Геодезийн өндрийн загвар батлах тухай/ • БХБ-ын Сайдын 2019 оны 38 дугаар тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам” • “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам” ГЗГЗЗГазрын даргын 2020 оны А/40 дугаар тушаал. • Бусад хот байгуулалт, барилга байгууламжийн норматив баримт бичиг, норм, дүрэм, заавар <p>Судалгааны материалууд:</p> <ul style="list-style-type: none"> • Инженер хайгуулын судалгааны дүгнэлт, газрын зураглал; • Орон нутагт хийгдсэн ерөнхий төлөвлөгөөтэй холбоотой судалгааны материалууд; • Урьд хийгдсэн хөрсний болон усны хайгуулын судалгааны материал.
6.	Баримт бичгийн бүрдэл	<p>Зураглалын материал</p> <ul style="list-style-type: none"> • Бүсийн хөгжлийн тойм, нутаг дэвсгэрийн байршлын схем М1:500000; • Орчны тойм М1:5000-25000; • Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ М1:5000; • Барилгажилт, дэд бүтцийн хангамжийн одоогийн байдал М1:2000 • Газар ашиглалтын одоогийн байдал М1:5000, М1:2000 • Багийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /батлагдах/ М1:2000, М1:1000 • Багийн төвийн барилгажилт /эхний ээлж/ • Гудамж зам, тээврийн сүлжээ /батлагдах/ М1:5000, М1:2000 • Нийгмийн дэд бүтэц М1:5000, М1:2000 • Газар зохион байгуулалт М1:5000, М1:2000 • Инженерийн хангамжийн төлөвлөлтийн нэгдсэн зураг /батлагдах/ М1:5000, М1:2000 • Дулаан хангамж М1:5000, М1:2000 • Ус хангамж, ариутгах татуурга М1:5000, М1:2000 • Цахилгаан хангамж М1:5000, М1:2000 • Холбоожуулалт М1:5000, М1:2000 • Инженерийн бэлтгэл арга хэмжээ М1:5000, М1:2000 • Өндөржилт, Улаан шугам М1:5000, М1:2000 • Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж М1:5000, М1:2000 • Ерөнхий төлөвлөгөөний 3 хэмжээст харагдах байдал <p>Тайлбар бичиг</p>

		<p><i>Дараах асуудлуудыг судалгаа, тооцоонд тулгуурлан тодорхой тусгасан байна. Үүнд:</i></p> <ul style="list-style-type: none"> • Ерөнхий төлөвлөгөө боловсруулсан үндэслэл, аргачлал; • Хот байгуулалтын суурь судалгаа, дүгнэлт, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, харьцангуй давуу, сул талуудын харьцуулалт, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүдийн тодорхойлолт, эдийн засгийн тооцоо; • Төлөвлөлтийн үндсэн шийдэл, хөгжлийн стратеги; • Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах /Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахдаа төлөвлөлтийн үе шатны дагуу эрэмбэлж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийн тооцоог бодитойгоор хийнэ/. • Хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн жагсаалт; • Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлт; • Барилгажих арга хэмжээ, ээлж дараалал; • Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх хурлын тэмдэглэл холбогдох баримтууд. <p>Тайлбар: Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд барилга байгууламж, тохижилт, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн өгөгдөл оруулах” -ын журмыг баримтлана.</p> <p>Батлагдсан ажлын даалгаварт тусгагдсан иж бүрэн зураг төслийн эх хувь, тайлбар бичгийн хамт хэвлэмэл болон тоон байдлаар CD-нд 3 хувь үйлдэж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын https://egazar.gov.mn/ мэдээллийн сан, Архангай аймгийн Архивын назар, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Засаг даргын Тамгын газарт тус бүр хүлээлгэн өгөх.</p>
7.	Шийдвэрлэх үндсэн асуудлууд	<ul style="list-style-type: none"> • Багуудын сум болон аймгийн эдийн засгийн хөгжил, хүн амын нутагшил суурьшлын тогтолцоонд эзлэх байр суурь, чиг үүргийг оновчтой тодорхойлох; • Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгсний үндсэн дээр хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн архитектур, барилгажилт, тохижилт бүхий орон зайн зохистой төлөвлөлт бүхий эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх; • Сумын иргэдийн тогтвор, суурьшилтай, ая тухтай амьдрах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай суурь судалгааг хийж, судалгаанд үндэслэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой байх; • Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд заасан хот байгуулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх газруудын байршил, төрлүүдийг тодорхойлон авах арга хэмжээний санал боловсруулах; • Нутаг дэвсгэрийн бүсчлэлийг хот төлөвлөлтийн норм ба дүрэм, журмын дагуу төлөвлөх, инженерийн шугам сүлжээ болон авто замын хамгаалалтын зурвас газрыг тогтоох ;

		<ul style="list-style-type: none"> • Ирээдүйн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан суурьшлын нөөц бүс тогтоох; • Хог хаягдлын менежментийн бодлогыг тодорхойлох; • Инженерийн дэд бүтцийн найдвартай эх үүсвэрийг бий болгох; • Хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын уялдааг хангах; • Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийгдэх сонгосон газарт байр зүйн дэвсгэр зураглалын геодезийн ажил, хөрсний инженер геологийн хайгуул судалгааны ажлыг эрх бүхий байгууллагаар гэрээ, ажил гүйцэтгэх даалгаврын дагуу иж бүрэн хийлгэх; • Инженер геологийн судалгаа, хөрсний шинж чанар, байгаль цаг уурын нөхцөл, газрын гадаргын тогтолцоотой уялдуулан инженерийн бэлтгэл арга хэмжээний инженерийн шийдлийг зөв тодорхойлон үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөх; • Байгаль орчинг хамгаалах, унаган дүр төрхийг хадгалах, доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ тусгах; • Багийн төвийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээ тусгах; • Хөгжүүлж болон эрхэлж болох жижиг дунд, өрхийн үйлдвэрлэлийг тодорхойлох тэдгээрийн байршлыг зөв тогтоон гаргах; • Сэргээгдэх эрчим хүч ашиглах боломж, эрчим хүчний хэмнэлттэй байх нөхцөл бүрдүүлэх.
8.	Инженерийн байгууламж, шугам сүлжээний эх үүсвэр, хангамж	<p>Ус хангамж</p> <ul style="list-style-type: none"> • Одоо байгаа эх үүсвэрүүдийг ашиглах боломжийг судлан ус хангамжийн цагираг шугамд холбохоор төлөвлөнө, шаардлагатай тохиолдол геофизикийн хайгуулын судалгаанд тулгуурлан уст цэгийг нэмж тодорхойлно; <p>Ариутгах татуурга</p> <ul style="list-style-type: none"> • Одоо байгаа барилгууд болон төлөвлөлтөд тусгагдсан барилгуудын ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг дэвшилтэд технологи ашиглахаар шийдвэрлэх. <p>Цахилгаан хангамж</p> <ul style="list-style-type: none"> • Ирээдүйн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг тодорхойлон барилгажилтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх. <p>Холбоожуулалт</p> <ul style="list-style-type: none"> • Өгөгдлийн холбооны өндөр хурдны сүлжээнд холбохоор төлөвлөх; <p>Инженерийн хангамжийг техникийн шийдлийн дагуу эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн технологитой байхаар төлөвлөх, гудамжны гэрэлтүүлэгт сэргээгдэх эрчим хүч / нар, салхи/-ийг ашиглахаар талаар тусгах.</p>
		<ul style="list-style-type: none"> • Тухайн орон нутгийн байгаль цаг уур, газар зүйн нөхцөл, нийгэм эдийн засгийн онцлогийг тусгасан барилгажилт, тохижилт бүхий орон зайн бүтэцтэй хот төлөвлөлтийн онцлог шийдлийг гаргах; • Гэр хорооллын төлөвлөлт, замын сүлжээ, үйлчилгээг боловсронгуй хүртээмжтэй болгох; • Шинээр төлөвлөлт хийх нутаг дэвсгэрт газар эзэмшиж, ашиглаж, өмчилж буй байдлын судалгаа хийж, байгууллага

9.	Төслийн онцгой нөхцөл	<p>болон сумын иргэдээс төлөвлөлтөд тусгах зорилгоор санал асуулга, судалгаа явуулсан байх;</p> <ul style="list-style-type: none"> • Ундны болон ахуйн хэрэгцээний усны асуудлыг онцгой судлан, шийдлийг гаргах; • Инженер-геологийн нөхцөлөөс хамааруулан инженерийн бэлтгэл арга хэмжээ болон байгалийн аюултай үзэгдэл, гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зэрэг арга хэмжээг төлөвлөх буюу эрсдэл өндөртэй газарт цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай зэрэг барилгажилт багатай бүс төлөвлөх; • Төлөвлөлтийн шийдэл, нутаг дэвсгэрийн үүргийн бүсчлэл, газар зохион байгуулалт, газар дахин төлөвлөлттэй холбогдолтой асуудлыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, аймгийн Ерөнхий архитектор, сумын төвийн нийгэм эдийн засгийн хөгжил, дэд бүтэц, байгаль орчин, хөрөнгө оруулалтын асуудлыг сумын Засаг даргын Тамгын газартай зөвшилцөх; • Зурагт төсөлд тодорхой ишлэл авсан техникийн баримт бичгийг тодорхой заах, холбогдох тооцоо, судалгааг тайлбарт нарийвчлан тусгах; • Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх; • Ерөнхий төлөвлөгөөний зураглалыг “Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг” MNS 6736:2018 стандартыг баримтлан зураглаж, Хот байгуулалтын мэдээллийн санд оруулах; <p>- ЗТБХБСайдын 2012.06.13-ны №183 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий төлөвлөгөөний төсөлд олон нийтээр хэлэлцүүлэх журам”-ын дагуу суманд хэлэлцүүлэг хийх /Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулах/, иргэд, байгууллагуудын саналыг төлөөлөгч томилон 7-с доошгүй хоног авах, төлөвлөлтийн санал авах.</p> <p>- Төлөвлөлтийн шийдлийг сумын болон аймгийн Засаг дарга, ИТХ, мэргэжлийн байгууллагатай зөвшилцөх;</p> <p>- Ерөнхий төлөвлөгөөг мөрдөх, хэрэгжүүлэх талаар орон нутгийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, иргэд байгууллагуудад сургалт зохион байгуулах.</p>
10.	Боловсруулах хугацаа	<p>Гэрээнд заасан хугацаагаар</p> <p>Эхлэлийн тайлан:</p> <ul style="list-style-type: none"> - Одоогийн байдлын судалгаа, байр зүйн зураглал, инженер геологийн судалгаа дууссан байх, одоогийн байдалд үнэлэлт дүгнэлт хийх, судалгааны түвшинд харьцуулсан хувилбар дэвшүүлж төлөвлөлтийн тооцоолол боловсруулах; - Олон нийтээс санал авах /Төлөвлөлтийн хязгаарт хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас санал авах/ <p>Дундын тайлан:</p> <ul style="list-style-type: none"> - Эхлэлийн тайланд өгсөн саналыг тусгаж төлөвлөлтийн үе шатанд тавигдах шаардлагын дагуу төлөвлөлтийг гүйцэтгэсэн байх;

		- Төлөвлөлтийн шийдлийг олон нийтэд танилцуулж хэлэлцүүлэг хийх /Төлөвлөлтийн хязгаарт хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төр захиргааны байгууллагуудад танилцуулж хэлэлцүүлэг хийх/ Эцсийн тайлан: Ерөнхий төлөвлөгөөнд мэргэжлийн байгууллагаас өгсөн санал, дүгнэлтийг тусгаж эцсийн байдлаар хүлээлгэн өгөх. Магадлалаар хянагдах хугацаанд энд тооцоогүй тул гэрээний тусгай нөхцөлд заана.
11.	Шаардах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлнэ. 54,000,000 төгрөг
12.	Захиалагч байгууллага	Сумын Засаг даргын тамгын газар Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
13.	Гүйцэтгэгч байгууллага	Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах тусгай зөвшөөрөлтэй Аж ахуй нэгж, байгууллагыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу сонгон шалгаруулж гүйцэтгүүлнэ;
14.	Зөвшөөрөлцөх байгууллага	<ul style="list-style-type: none"> • Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, аймгийн Ерөнхий архитектор болон Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газартай зөвшөөрөлцөх; • Зураг төсөлд улсын экспертиз хийлгэж, нэгдсэн дүгнэлт гаргуулах. • Аймаг, сумын Засаг дарга; • Аймгийн Онцгой байдлын газар; • Орон нутгийн хангагч байгууллагууд;

ЗӨВШӨӨРСӨН:

АЙМГИЙН ГХБХБГ-ЫН ДАРГА

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

АЙМГИЙН ГХБХБГ-ЫН БХБХ-ИЙН ДАРГА
БӨГӨӨД ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР



Ч.ОТГОНЖАРГАЛ

А.БАТБОЛД

Л.ЛХАСҮРЭН